



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/442

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Аймгийн төвийн хяналтын камерыг өргөтгөх, шинэчлэх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Тийм эттэ" ХХК-тай 99 800 632 /Ерэн есөн сая найман зуун мянга зургаан зуун гучин хоёр/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Цагдаагийн газар (Л.Ганбаатар)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Цагдаагийн газар (Л.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Тийм эттэ" ХХК-ийн захирал (Х.Баттулга)-д даалгасугай.

4. Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6323010474

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 сарын  
31 өдрийн 4/47 дугаар захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	1,717,323	Л.Ганбаатар
2	Захиалагчийн албаны зардал	1,717,323	Л.Ганбаатар
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	900,000	Л.Ганбаатар
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	858,662	Л.Ганбаатар
5	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
6	Ажил гүйцэтгэх хугацаа	60 хоног	Л.Ганбаатар
7	Гүйцэтгэлийн баталгаанй дүн	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь.	Д.Батцогт